Манмин Мэдээ

№ 80 2020 оны 1 сарын 26

“Эзэнийг оршихуйг батлах үг ба дагалдах тэмдэгийг хүсэн тэмүүлж байна!”

Венесуель дэх 5удаагийн сайн мэдээ тараалт, 120орчим сүм хамтарсан сүмээр бүртгэгдэв.

Өмнөд Америкт орших Венесуельд 5дах удаагийн сайн мэдээ тараах үйл ажиллагаа 11-р сарын 29нөөс 12-р сарын 1ныг хүртэл Жан Жон ён пастор (Колумби Манмин сүмийн хариуцсан) удирдан явууллаа. Энэ удаагийн үйл ажиллагаа нь өнгөрөгч 9-р сард Венесуель 4дэх удаагийн сайн мэдээний тараах үйл ажиллагаа нь ивээл авч, эрх мэдэлт хүчний нөлөөг авсан Елисэё пастор тэргүүтэй хэсэг номлогч нар нэгдээд урилгаар явагдсан зүйл юм.

Эхний хөтөлбөр нь 11-р сарын 29ний өдөр пастор, ажилчдын семинар Парикешмэто хотод Цөл дэх амийн булаг цуглаанд 700гаруй хүнтэй явагдлаа. И Жей руг тэргүүн пасторын эрх мэдэлт хүч нөлөө агуулагдсан видеог үзсэний дараа Жан Жон ён пастор ‘Ариун Сүнс’ (Лук 3:16) гэсэн сэдвээр семинарийг хөтлөн явуулж, үгийг хичээнгүйлэн сонсож байгаа оролцогчид хэд хэдэн удаа алга ташиж байлаа. Үргэлжлүүлэн И Жей руг тэргүүн пасторын залбирч өгсөн эрх мэдэлт хүчтэй гар алчуур (Үйлс 19:11-12)-р залбирч өгтөл тэр даруй доод эрүү мултрах, хүзүүний нугалам үеэр өвдөх, хөхний үрэвсэлт өвчнөөсөө эдгэрч Бурхандаа алдрыг өргөж байв.

Хорге Пачеко пастор “Дагалдах тэмдгээр үгийг баталж өгсөн энэ үйлчлэлтэй хамт байхыг хүсэж байна” гэж байлаа. Энэ өдөр 120иод сүм чуулган манмины үйлчлэлтэй нэгдэхээр хамтарсан сүмээр бүртгэгдсэн юм.

Нэг талаар уг семинарт үйлчилж байсан нэг итгэгч “2006онд АНУ Медисон Скюэрэ гарденд ‘И Жей руг тэргүүн пасторыг урьсан Нью-Йорк нэгдсэн их цуглаан’-д оролцсон гэр бүлийн хүн маань утсаар дамжуулан Венесуельд залбирал авч нүдний болорын хорт хавдраас эдгэрсэн” гэж баяртайгаар гэрчилж байлаа. Энэ өдрийн орой Жан пастор LBD TV-д ярилцлага өгч манминий үйлчлэлийг танилцуулсан юм.

11-р сарын 30нд ‘Есдатио дэ 12октубре’ гольфийн цэнгэлдэх хүрээлэнд 12000-д хүн цугларсан эдгэрэл ивээлийн цуглаан болж өнгөрлөө. Жан пастор ‘Есүс аврагч Эзэн болсон учир’ (Үйлс 4:12) тухай сургаал заасны дараа эрх мэдэлт хүчтэй гар алчуураар залбирал хийж өгсөн юм. Тэгтэл нүдний хараа сайжирч, алхаж чадахгүй хүүхэд алхдаг болж, төрөл бүрийн өвчнүүд эдгэрсэн зэрэг агуу эрх мэдэлт хүчийг харж мэдэрсэн оролцогчид алдрыг өргөж байлаа.

12-р сарын 1ны Эзэний өдөр Цөл дэх амийн булаг цуглаан, Хадан суурь, Бурханы ивээл цуглаан зэрэг гурван цуглаан тус бүр цуглаан удирдан явуулж сүнс талын гүн үг сургаалиар номлогч нар итгэгч нар сэтгэл хөдлөл ба их ивээл авсан юм. Энэ удаагийн семинари болон цуглаануудийг бэлдсэн номлогч нар “Манмин библи суурьтай сайн мэдээ тараадаг”, “Бурханы агуу хүч чадал гарч Эзэнд баттай итгүүлж байна” гэцгээж дахин ирж цуглаан хийж өгөхийг хүсэж байна гэлцэж байна.

‘Сүнслэг хайр’ цуврал 10

Хорон мууг бодож тооцоо хийдэггүй хайр

“Хайр бол тэвчээртэй, энэрэнгүй юм. Хайр атаархдаггүй, бардам зан гаргадаггүй, ихэрхдэггүй. Зохисгүй авирладаггүй, өөрийнхнийг эрдэггүй, уурладаггүй, муутай тооцоо хийдэггүй.”
1 Коринт 13:4-5

И Жей руг тэргүүн пастор

Номлогчийн ажил хийхэд маш олон хүмүүстэй уулздаг. Бурханы тухай сануулж л өгөхөд сэтгэл хөдлөл нь далайн давалгаа мэт ундран гарч нулимс урсгадаг хүн байдаг бол Бурханд итгэж хайрладаг ч “Надад яагаад Бурхан сайн мэдрэгдэхгүй байна?” гэж шаналдаг хүмүүс ч байна.

Бид итгэлийн амьдралаар амьдарч байхдаа заримдаа хүнд байдалтай учрах үе байдаг. Тэр үед хувиршгүйгээр биднийг хүлээж буй Бурханы хайрыг эргэн санавал хангалттай ялах боломжтой юм. Гэвч Бурхан руу хандсан хайрын хэмжээ нь хэр зэрэг ‘Гэм буруутайгаа тэмцэн хаяж, өөрчлөгдөж байгаа вэ’ гэсэн асуултад байдаг. Бурханы үгийн дагуу үйлдэн сзрх сэтгэлээсээ хорон мууг хаях тусам итгэл нь зогсонги бололгүй, Бурханы хайрыг гүн мэдрэх болдог.

Тэгвэл ‘Хорон мууг боддоггүй хайр’ гэж юу вэ? Эндээс хоронг муу гэдэг нь ‘Бурханы үгээр илрүүлэн харахад Бурханы хүсэлд нийцэггүй бүх зүйл’-г хэлдэг юм.

1. Бурханы хүсэлд нийцдэггүй хорон муу бодлууд

1) Бусдыг бүтэлгүйтэхийг хүсдэг бодол

Жишээ нь хэн нэгэнтэй маргалдаад нөгөө хүнээ үзэн ядсандаа ‘Явж байгаад тээглээд ойчоосой’ гэсэн бодол орж ирлээ гэж бодъё. Мөн хооронд харьцаа муу хөршдөө таагүй зүйл тохиолдоход дотроо ‘Болж болж’, ‘Аятайхан байна’, ‘Тэгнэ гэж мэдэж байсан юм’ гэж бодох талаар юм. Эсвэл надаас илүү хичээл сайн хийдэг хүүхэд ‘Шалгалтаа муу өгөөсэй’ дотроо хүсэх тохиолдол юм.

Зүрх сэтгэлд хайр байвал энэ мэт хорон муу бодол боддоггүй юм. Хайртай хүн нь өвдөх юм уу, осолд орохыг хүсдэг хүн гэж байхгүй юм. Миний эхнэр, миний нөхөр, миний хүүхэд үргэлж эрүүл саруул, аюулгүй байхыг хүсдэг. Хайр байхгүй учраас л бүтэлгүйтэхийг хүсэж, бусдын зовлонд баярладаг.

Хайр байхгүйн улмаас бусдын алдаа дутагдал, сул талыг илчлэх гэж түүнийг дамжуулах гэдэг. Хэрвээ өөрт хамаарах бүлэг, цугларалтад хэн нэгэн нь өөр нэгэний тухай олигтой юм ярьж байхад тэр яриаг сонсох гэж чих тавьж байгаа бол өөрийгөө эргэж харах хэрэгтэй юм. Мэдээж бусад хүмүүс буруу замаар явахыг хориглож, бусдад туслахын төлөө гараа сунгаж мэддэг байх хэрэгтэй. Тийм биш байсан ч элдэв ярианд дуртай бол нэлээн бусдын мууд дурладаг хов живэнд дуртай байдаг учраас юм. Цайлган хайр ихтэй хүн нь бусдын алдааг хучиж далдлах гэдэг (Сургаалт үгс 17:9).

Сэтгэлд сүнс талын хайр бйвал бусад хүн амжилт олоход атаархдаггүй бөгөөд улам их амжилтад хүрэх, хайр хүртэхийг хүсдэг. Есүс “Та нар дайснаа ч хайрлаж, та нарыг хавчдаг хүмүүсийн төлөө залбир” (Матай 5:44) гэсэн байдаг бол Ром 12:14д “Та наоыг хавчигч хүмүүсийг ерөө. Ерөө, харин бүү хараа” гэсэн байдаг.

2) Бусдыг дүгнэж шүүдэг бодол

Хэрэв хэн нэгэн итгэгч хүнийхээ хувьд очих зохисгүй газар орж байгааг харвал юу гэж бодох вэ? Сэтгэлд хорон муу байх хэмжээгээр ‘Яаж тэгж чадаж байна?’ гэсэн муу бодолд автдаг. Зүрх сэтгэл үүнээс бага зэрэг цайлган бол үүнийг хармагцаа ‘Ийшээ орох ямар шалтгаан байгаа биз?’ сайнаар бодох гэж хичээдэг. Тэгтэл сүнслэг хайр байвал хорон муу бодол орох зайгүй юм.

Хэдийгээр бусдын тухай сайн бус үгийг дамжуулан сонслоо ч гэсэн үнэн худлыг нь шалгах хүртэл яаран дүгнэлт гаргадаггүй. Ихэнх эцэг эхчүүд өөрийн үр хүүхдийн тухай муу үгийг сонсоод “Миний хүү тэгэх учиргүй” гэж амархан хүлээж авдаггүй. Харин ч энэ үгийг дамжуулж буй хүнийг хүртэл буруутгаж боддог. Хайртай хүний тухай яадаг ч байсан сайнаар боддог учраас юм.

Өнөө үед маш амархан бусад хүний талаар муугаар бодож, буруутгаж, өө хайдаг. Энгийн харилцаатай хүмүүс хооронд төдийгүй олон нийтийн нийгмийн хүрээнд ч дүгнэх шүүх явдал газар авсан байдаг. Бүр цаашлаад бусдын одоогийн болон өмнөх амьдрал,

ямар ч хамааралгүй үг яриаг ч дамжуулдаг.

Интернетээр цацагдсан цуу үг, дамжсан яриа нь элдэв сөрөг сэтгэгдэлүүдээр газар авч, үүний улмаас хүмүүс амиа хорлох явдал ихэссэн нь өнөөгийн нийгмийн том асуудал болсон нь бодит байдал юм. Үнэн болох Бурханы үг биш өөрсдийн хэмжүүрээр бусдыг дүгнэж шүүж байдаг. Тэгвэл Бурханы сайхан хүсэл нь юу вэ?

Иаков 4:12-д "Хууль Тогтоогч ба Шүүгч нь зөвхөн ганц байдаг бөгөөд Тэр нь аварч, устгаж ч чадна. Харин хөршөө шүүгч та хэн юм бэ?" гэсэн байдаг. Эндээс зөвхөн Бурхан л шүүх эрх мэдэлтэйг харуулж байгаа ба хөршөө дүгнэн, шүүх нь хорон муу юм гэж байгаа юм.

Эргэн тойрны чинь хүн илэрхий буруу юм хийсэн тохиолдолд ч сүнслэг хайрыг хайдаг хүнд 'Энэ, тэр хүн зөв, ийм тийм' гэх яриаг далдлах нь чухал биш 'Яавал түүнд үр ашигтай байх вэ' гэдгийг түрүүлж боддог. Ямар ч үед тэр хүн өөрчлөгдөөд Бурханы хайрыг авахыг хичээнгүйлэн хүсдэг юм.

Цаашлаад төгс хайр нь бусдын алдааг далдалж өгч, уучлах төдийгүй гэмшихэд нь ч туслах хэрэгтэй. Зөв замаар явахад нь дэмжиж үнэнийг мэдүүлж өөрчлөгдөх сэтгэл хөдлөлийг өгч чадах хэрэгтэй юм.

Сэтгэлдээ сүнслэг хайрыг төгс бий болговол бусдыг сайнаар харах гэж хичээх хэрэггүй юм. Хичнээн алдаа дутагдал, сул тал ихтэй хүнийг ч хайрладаг тул яадаг ч гэсэн итгэж өгч, тусалж өгөхийг хүсдэг. Энэ мэтчилэн дүгнэж шүүх бодол огт байхгүй бол хэнтэй ч уулзсан ч аз жаргалтай байдаг.

3) Бурханы хүслийн эсрэг бүх бодол санаа

Энгийн үгээр бусдын талаар хорон муу бодол өвөрлөх төдий бус Бурханы хүслийн эсрэг ямар ч бодол бол хорон муу бодол юм.

Ихэнх хүмүүс ёс суртахуунтай хүнлэг хүний сайн хүн цайлган гэдэг. Гэсэн ч ёс суртахуун хүнлэг мөс чанар нь сайны гол хэмжүүр болж чаддаггүй юм. Бүр цаашлаад Бурханы хүслээс тэс өөр эсрэг зүйл ч байж болзошгүй юм. Зөвхөн Бурханы үг л сайн туйлын хэмжүүр юм.

Анх Эзэнийг хүлээн аваад өөрийгөө гэмтэн гэдгээ ухаардаг. Цайлган сайнаар амьдарсан гэж өөрөөрөө бахархдаг хүн ч Бурханы үгээр өөрийгөө эргэж харахад "Би гэмтэй. Хорон муу хүн" гэж хэлэхээс ч аргагүй юм. Сайны гол хэмжүүр нь Бурханы үгийн эсрэг бүх зүйл хорон муу бөгөөд атгаг зүйл юм (1 Иохан 3:4).

Тэгвэл гэм нүгэл ба атгаг байдлын ялгаа нь юу вэ? Томоор авч үзвэл гэм нүгэл хийгээд хорон муу бүгд Бурханы үгийн эсрэг болох хорон муу, худал хуурмаг зүйл юм. Гэрэл болох Бурханы эсрэг тал харанхуйн үйлс юм. Илүү нарийн ойрхон авч үзвэл гэм нүгэл ба хорон муу хоёрт ч бас ялгаа байдаг.

Модоор зүйрлэвэл 'Хорон муу' гэдэг нүдэнд харагдахгүй ч газрын хөрсөнд суугдсан үндэс мэт зүйл юм. Гэм нүгэл бол нүдэнд харагдах мөчир болон навч, үр жимс нь юм.

Үндэс байхгүй бол модонд мөчир, навч үр жимс байдаггүй шиг гэм нүгэл нь хорон муугаас гарах үр дүн юм. Өөрөөр хэлбэл хорон муу гэдэг нь газарт гүн суугдсан үндэстэй адил Бурханы сайн болон хайр, үнэний үгийн эсрэг зүрх сэтгэл дэх 'гэмийн шинж чанар' юм. Энэ хорон муу нь тодорхой хэлбэр дүрс үйлсээр илчлэгдэн гарах үр дүн нь гэм нүгэл юм.

Хэрэв зарим хүмүүс бүдүүлэг үгс, хараал хэлэх юм уу өргөс мэт өдөөн хатгах үг болон үйлсээр бусдыг хүнд байдалд оруулбал сэтгэлд буй үзэн ядалт гэх хорон муу байдал тодорхой үйлдлээр илрэн гарч байгаа хэрэг юм (Лук 6:45). Гэм нь Бурханы үг, өөрөөр хэлбэл 'Хууль' гэх хэлбэрээс бүрэлдэн тогтож хэрэгждэг юм. Үзэн ядалт, атаархал, жөтөөрхөл, завхайрал, зэрэг махан биеийн бодол болон маргаан, уур хилэн, хулгай, аллага зэрэг махан биеийн үйлсээр маш тодорхой тус тус ялгардаг.

Гэвч сэтгэлд хорон муу байлаа гээд зайлшгүй гэм үйлддэг гэдэг зүйл бас биш юм. Хүмүүжилтэй мөн Бурханы үгийг сонсоод тодорхой хэмжээнд биеэ захирдаг болсон бол сэтгэлд хорон муу байлаа ч үйлсээр гэм хийдэггүй. Энэ тохиолдолд том гэм үйлдэгүй ч 'Би ариун байдлыг бий болгочлоо' гэж тайвширч болохгүй юм. Тийм ч учраас сэтгэлийн уг гүнд суугдсан хорон муугийн шинж чанарыг хаяж байж ариун байдлыг бий болгох юм.

Хүн болгон сэтгэлийн угт эцэг эхээс дамжин ирсэн хорон муу байдаг ч тэр төдийлэн ил гардаггүй ч зайлшгүй нөхцөлд тэр нь илрэн гарах болдог. Хэдийгээр гэм нүгэл хийгээгүй ч өө сэвгүй, төгс Бурханы үгтэй харьцуулахад нийцээгүй бүх зүйл хорон муу бөгөөд тийм ч учраас "Хорон муугийн хэлбэрийг хая" (1 Тесалоник 5:22)-д захисан байдаг.

Бурхан бол хайр юм. Бурханы хууль тушаал ч ойлгоход амархан хураангуйлбал 'Хайр' юм (1 Иохан 3:23; Ром 13:10). Эцэстээ хайрлахгүй байна гэдэг нь хорон муу бөгөөд гэм нүгэл юм. Би хэр зэрэг сүнслэг хайрыг бий болгосноо мэдэхийг хүсвэл хорон мууг бодож байна уу үгүй юу гэдгээ эргэн харах хэрэгтэй юм. Бурхан болон хүмүүсийг хайрлах тусам хорон мууг бодол байдаггүй учраас юм.

2. Хорон мууг боддоггүй хайрыг бий болгохын тулд

1) Хорон муу зүйлийг харахгүй сонсохгүй байх хэрэгтэй

Хэдийгээр хорон муу зүйлийг харж, сонссон ч эргэн санах, сэтгэлдээ хадагалахгүй байх тал дээр хичээх хэрэгтэй юм. Мэдээж өөрийн бодлоо хүссэнээрээ захирч чадахгүй уе ч бий. Бодохгүй байхын тулд илүү цөхрөлтгүй чармайх хэрэгтэй ч хорон муу зүйлийг бодохгүй байхын төлөө тасралтгүй зүтгэнгээ залбирвал Ариун Сүнснээс туслаж өгөх болно. Хорон муу зүйлийг зориуд үзэж, сонсвол үүнийгээ мэдэж болих ба дахин санахгүй байх тал дээр агшин зуурч зурсхийх бодлоо хүртэл хаях хэрэгтэй юм.

2) Хорон муу үйлсэд хамтран оролцож болохгүй юм

2 Иохан 10-11д "Хэрэв хэн нэгэн нь та нар руу ирэхдээ энэ сургаалыг

авчрахгүй бол, түүнийг гэртээ бүү оруул. Түүнтэй мэндэлж болохгүй. Түүнтэй мэндэлж буй хүн нь түүний бузар үйлсэд оролцож байгаа хэрэг юм” гэсэн байдаг. Чин сэтгэлээсээ хорон муу байдлыг анхааруулж, бүү оролц гэж захисан байгааг олж харж болно.

Хүн бүрт өөрийн гэмийн шинж чанар, болон өсөж байжих явцад үзэж сонссон худал хуурмагийн дагуу өөрийн бие хүнийг бий болгосон байдаг. Эзэний хүлээн авсаны дараа ч иймэрхүү гэмийн шинж чанарааа хаяж засах нь итгэлийн амьдрал юм. Гэвч гэмийн шинж чанар болон хорон мууг хаях нь маш их тэсвэр тэвчээр зүтгэл хэрэгтэй юм. Энэ дэлхийд амьдармагцаа үнэн гэхээс илүү хорон мууд дасаж, энэ хорон муу хүлээн авах амархан ч хаяхад харьцангуй хүнд байдаг учраас юм.

Цагаан хувцсанд хар бэх нэг дусаахад маш амархан ялгаран харагддаг жижигхэн толбо нь улам газар авч томрох боломжтой шиг эргэн тойрны хүмүүст асар хурдацтай тархдаг (Галат 5:9). Түүнчлэн өчүүхэн хорон муу байдлыг ч анхааруулж дахин сануулах хэрэгтэй юм. Хорон муугийн бүх хэлбэрийг ч хаяхыг хүсдэг бол шууд тэр хорон муу байдлыг жигших хэрэгтэй юм (Дуулал 97:10; Сургаалт үгс 8:13).

Хэрэв хэн нэгэнийг халуунаар хайрлавал түүний дуртай зүйлд ч дуртай болж, жигшдэг зүйлийг ч хамт жигшдэг юм. Үүний нэгэн адилаар Ариун Сүнс авсан Бурханы хүүхдүүд нь гэм нүлэл үйлдвэл Ариун Сүнс гашууддаг сэтгэл хоосрон тавгүйтдэг. Тиймээс ‘Бурхан үүнийг жигшдэг байхнээ’ гэсэн ухаарал ирж дахин тийм гэм хийхгүй байхын төлөө хичээх хэрэгтэй юм. Ингэж хорон мууг жигшиж, бүх л атгаг хэлбэрийг хаях төдийгүй цаашид тийм зүйлийг хүлээж авахгүй байх нь илүү чухал юм.

3. Бурханы үг ба залбирлаар дэмжлэг авах хэрэгтэй

Галат номын 6:7д “... Юу гэвэл хүн тарьснаа л хурааж авдаг” гэсний дагуу хорон мууг суулгавал гай зовлон амсахаас төдий юм (Сургаалт үгс 22:8). Өөрөө ч төдийгүй хайртай хүүхдээ өвчин тусах юм уу, осолд орох, ядуу тарчиг байдал, гэр бүлийн амгалан тайван бус байдлын улмаас уйтгар дотор амьдрах зэрэг ийм тийм асуудлууд ч эцэстээ суулгасан хорон муугаас үүдэлтэй юм. Мэдээж гай зовлон үдүү шууд ирэхгүй ч байж болох юм. Ийм тохиолдолд хураагдсан тэр хорон үйлс нь хэвийн хэмжээнээс хэтэрч, тэдний үр удамд нөлөөлж ч болзошгүй юм.

Олон хүмүүс энэ зүйлийг мэдэхгүй нь улмаас том бага хорон үйлсийг хийхэд огт эргэлздэггүй. Жишээ нь надад хохирол учруулсан хүнд хариуг нь өгнө гэдэг мэдээжийн зүйл гэж боддог. Тэгтэл Бурхан “Хорон муугийн хариуг би өгнө дөө гэж бүү ярь. Эзэнийг хүлээ, тэр чамайг аварна” гэсэн байдаг бөгөөд ямагт сайныг үйлдэхийг хүсдэг.

Бурхан шударга ёсны дагуу хүн төрөлхтөний үхэл амьдралыг удирддаг. Тийм ч учраас Бурханы үгийн дагуу сайныг үйлдэн заавал сайн үр жимсийг хураан авдаг (Е.Гарсан нь 20:6). Бид хорон муугаас өөрийгөө хамгаалахын тулд хорон сууг жигшиж, өөрийгөө хоёр зүйлээр үргэлж дэмжиж байх хэрэгтэй. Энэ нь ‘Үг’ ба ‘Залбирал’ юм.

Өдөр шөнөгүй Бурханы үгийг бясалгаж байж, хорон муу бодлыг зайлуулж, сайнаар бодох боломжтой. Яаж үйлдэх нь жинхэнэ хайр болохыг нарийн тодорхой аргачлалыг авах ч боломжтой юм. Мөн залбирангаа үгийг гүн бясалгаж, нягтлан үзэхэд ухаарч ч чадаагүй өөрийн бодол ба үг яриа үйлдэл дундах хорон мууг илрүүлэх боломжтой юм. Ариун Сүнсний бялхалаар гал мэт халуун мэт халуун залбирахад сэтгэл дэх хорон мууг хаях боломжтой юм.

Хайрт итгэгч та бүхэн, Бурханы хүсч буй сүнслэг хайрыг биелүүлэхийн тулд Бурханы хүсэлд нийцэхгүй бүхий хорон мууг харахгүй сонсохгүй байж, хорон муугийн хэлбэрийг ч хаях хэрэгтэй юм. Бурханы үг ба гар мат халуун залбирлаар богино хугацаанд хорон бүх шинжийг хаяад аз жаргалтай амьдралаар дүүрэн байхыг Эзэний нэрээр хүсэн ерөөе.

Mongolian
Манмин Мэдээ
Published by Манмин Төв Сүм
Сөүл хот, Гүрэ дүүрэг, дижитал-26-29тоот
152-848 Солонгос Улс
Утас: 82-2-818-7047 • Факс: 82-2-818-7048
http://www.manmin.org/english
www.manminnews.com
e-mail: manminminen@manmin.kr
Нийтлүүлэгч: Жаерок Лее

Монгол Манмин Сүм

Мөргөлийн цаг

Мөргөл	Цаг
Их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойш мөргөл	Ням гариг 13:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 10:00
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 22:00
Эмэгтэйчүүдийн багийн цуглаан	Лхагва гариг 16:00
Шинэ итгэгч нарын сургалт	Бямба гариг 14:00

Залбирлын цаг Цаг

Ангилал	Цаг
Даниел үүрийн залбирал	Даваа-баасан 5:00-6:00
Даниел өдрийн залбирал	Даваа-баасан 9:00-10:00
Даниел оройн залбирал	Өдөр бүр 18:30-20:00



Хаяг: Баянгол дүүрэг 16-р хороо Орхоны 1-33А Чуулганы ахлагч П.Батзориг Утас: 88107327, 91170773, 89737773 www.manmin.org www.gcntv.org

“Бурханы сайн хүсэлд итгэхэд ерөнхий менежер болж ерөөгдлөө!”

Ким Дүг соб сүмд үйлчлэгч (51нас, 3-р бүлэг 23-р хэсэг)

Би 1995оноос хойш 24жилийн турш гольфийн Сөүл Контри клубийн төв хэлтэст ажилласаар ирсэн юм. Энэ хугацаанд манай клубийн үйл ажиллагаа маш тогтвортой ашиг орлого сайтай байлаа.

Гэтэл 2018оны 12-р сарын 25нд гэнэт манай компани зарагдсан тухай мэдээлэл гарсан юм. Тэр өдөр шууд л 5хүнийг цомхтголд оруулж халагдах өргөдлөө өгөхийг хүлээн авч компани шаардсан юм. Алсдаа манай хэлтсийн дарга хүртэл солигдох болно гэсэн сураг гарч тэр хугацаанд амар тайван байсан манай компани үймэлдэж эхлэв.

Би амьд орших Бурханы сайхан хүсэл байгаа гэж итгэж байсан бөгөөд бүх зүйлээ Бурхандаа даатган сорилтын дараа их ерөөл байгаа найдан залбирсаар байлаа. Тэгтэл Инчоны төв байгуулагад миний хүсч байсан ажлын орон тоо гарсан тухай мэдэгдэл ирсэн юм. Гэвч би 23-р хэсгийн дэд удирдагчийн үүрэг хариуцаж байсан, мөн хамтдаа ажиллаж байсан хамт олноо хамгаалъя гэсэн бодол сэтгэлд бууж тэр саналыг орхисон юм.

Хэд хоногийн дараа манай төв байгууллагаас гайхалтай мэдээ сонссон юм. Манай компанийг авсан групп намайг ерөнхий менежерээр томилсон байлаа. Энгийн хугацаанд ажиллахад ийм богино хугацаанд ийм байр суурьд очно гэдэг нь төсөөлөхийн аргагүй ч Бурхан гайхамшигтай аргаар ерөөж өгсөн юм. Халлелуяа!

Би 2013оны 1-р сард сүмд бүртгэгдэн 10жил зовиурласан хамрын харшлийн үрэвсэл, мөрний өвчин, булчингийн өвчин зэргээсээ эдгэрсэн юм. Мөн гэрэл дотор амьдрахыг хичээж, хувиршгүйгээр төрөл бүрийн мөргөл болон Даниел залбирлийн цагтаа оролцож, авсан бүх үүргээ хүсэн чин сэтгэлээсээ хийхийн төлөө хичээсэн юм. Энэ бол И Жей руг тэргүүн пасторын сургаал үгээр дамжуулан Бурхан хүүхэд бол гэрэл дотор амьдрах ёстой талаар сурсан учраас юм.

Миний нүд дээгүүрх зүйлс рүү тэмүүлж, алдагдсан Бурханы төрхийг сэргээхийн тулд үргэлж удирдаж өгсөн Эзэндээ талархалыг өргөж байна. Итгэлээрээ гуйх болгонд хариулт ба ерөөлөөр хамт байж өгсөн Бурхан Аавдаа бүх талархал ба алдрыг өргөн барьж байна.

GCN Global Christian Network
Tel: 82-2-824-7107
www.gcntv.org
webmaster@gcntv.org

MIS Manmin International Seminary
Tel: 82-2-818-7334
www.manminseminary.org
manminseminary2004@gmail.com

WCDN World Christian Doctors Network
Tel: 82-2-818-7039
www.wcdn.org
wcdnkorea@gmail.com

Urim Books
Tel: 82-70-8240-2075
www.urimbooks.com
urimbook@hotmail.com

УБ Ариун баярт мэдээ чуулган

Мөргөлийн цагийн хуваарь

Мөргөл	Цаг
Хүндэтгэлийн их мөргөл	Ням гариг 10:30
Үдээс хойшхи мөргөл	Ням гариг 11:30
3 дахь өдрийн мөргөл	Лхагва гариг 18:00
5 дахь өдрийн мөргөл	Баасан гариг 21:30
Хүүхдийн цуглаан	Ням гариг 09:00
Сурагчдын цуглаан	Бямба гариг 15:00
Залуучуудын цуглаан	Мягмар гариг 17:00

залбирал цагийн хуваарь

Ангилал	Цаг	Удирдагч
Үүрийн залбирал	05:00-06:00	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Өглөөний залбирал	Даваа-Баасан 09:30-10:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч
Оройн Даниел залбирал	Өдөр бүр 18:00- 19:30	Г.Анхбаяр СМТ Чуулганы хариуцагч

Манай хаяг:
Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 10-р хороо 39-р сургуулийн чанх ард талд 2-р давхар саарал байр

Чуулганы утас: 7000-3707

Чуулганы ахлагчийн утас: 8870-3712

Е- шуудан: power3712@gmail.com

“Эзэн нурууны диск болон шамбарам өвчнөөс цэвэрхэн эдгээж өгсөн юм”

Александр Танасейев итгэгч
(42нас, Молдав Манмин сүм)

Би 2010оноос эхлэн телевизээр дамжуулан И Жей руг пасторын сургаалийг сонсдог болж түүнээс хойш интернэтээр байнга И Жей руг пасторын сургаалийг хайж сонсож ивээл аввдаг байлаа.

2017онд Молдав Манмин сүмийн тухай мэдээ сонсч эхнэртэйгээ хамт тэнд мөргөлд оролцдог болсон юм. Яг л өмнө явдаг байсан мэт тэнд очиход тэр хугацаанд сонссон сургаал яг надад зориулсан мэт ивээлтэй байлаа.

Үүнээс хойш бид Молдав Манмин цуглаанд явмагцаа итгэлийн амьдралийн цангаа тайлагдсан ч надад нэг асуудал байсан юм. Автомашины үйлдвэрт ажиладаг би удаан хугацааны турш нурууны дискний өвчнөөр ажил хийхэд маш хэцүү байлаа.

Эмч миний нурууны дээд нугаламд диск үүсч, нугаламд хооронд нэг тал руу шахагдаж, нэг талруу завсар гарсанаар мэдрэлийн судал хавчигдаж өвдөлт мэдрэгдэж байгаа гэсэн юм. Мэдээж эдгэрэхийн төлөө маш олон арга хэрэглэх гэж хичээсэн ч ямар ч үр дүнд хүрээгүй юм.

Би минь чулуу шиг хатуурч орой болоход маш их ядраад зүгээр хэвтээд өгмөөр санагддаг байлаа. Маш зовиуртай учир орондоо нааш цааш хөлбөрч, өвдөлттэйгөө тэмцэж ийм биетэй ажилдаа гарвал манай дарга удирдлага намайг төвөгшөөсөн байдалтай хардаг байв. Өөр ажил сураглаж үзсэн ч тийм амар биш нөхцөл бөгөөд мөн хоёр жоохон хүүхэдтэй тул хэцүү байсан ч ажилласаар байлаа.

Эдгэрнэ миний чин хүсэл бөгөөд нэн түрүүнд шийдэх асуудал байсан юм. Би хариулт авахын тулд Бурхан Аваас үр хүүхдүүдээсээ хүсч буй ариухан амьдаръя гэж хичээж сургаалиар дамжуулан миний дотор буй хаях ёстой зүйлүүд дутагдалтай зйүлүүдийнхээ төлөө залбирч, өөрчлөгдөх гэж хичээж байлаа. Үүний дараа Эзэн миний амьдралд нөлөөлж байгааг мэдэрч эхлэсэн юм. 2017оны 9-р сар, Бурхан Манмин төв сүмээс сайн мэдээний багийг Молдав руу илгээсэн юм.

Тухай үед мөн шамбарам өвчин тусаад хагалгаанд орох цаг авсан байсан ч би нурууны диск бол миний хамгийн том залбирлийн сэдэв байсан учраас шамбарамд нээх ач холбогдол өгөөгүй юм.

Тэгтэл И Жей руг пасторын залбирч өгсөн гар алчуур (Үйлс 19:11-12)-аар И Сү жин пастор миний нуруунд залбирч өгсөний дараа гайхалтай юм тохиолдов. Нурууны өвчин байхгүй болж, бие хөнгөрч, босоод биеэ хөдөлгөх боломжтой болж, би хүүгийнхээ гараас бариад үсэрч үзэхэд огт өвчин мэдрэхгүй болсон байлаа. Илүү гайхалтай нь шамабарам өвчин хүртэл төгс эдгэрсэн юм. Халлелүяа!

22-дох удаагийн хайрын кимчи хуваалцах, хэцүү амьдралтай хөршүүддээ дамжуулаа.

11-р сарын 19-20хүртэл Эмэгтэйчүүдийн багийн зохион явуулж буй ‘Хайрын кимчи хуваалцах’ үйл ажиллагаа болж өнгөрлөө.

Энэ жил 22-р удаагаа болж буй уг үйл ажиллагаа нь Эмэгтэйчүүдийн баг, Хятадын бүлгийн итгэгч нар сүмийн ажилтнуудтай хамт хайрын сэтгэлээ нэгтгэсэн юм.

Бэлэн болсон кимчи нь сүм доторх тусламж авдаг итгэгч нар төдийгүй Шиндэ бан 2-р хорооны эмэгтэйчүүдийн холбооны эрхлэгч Ан Хи жон нь “Манмин төв сүмийн итгэгч нарын чин сэтгэл шингээн өөрсдөө дарсан кимчи нь маш амттай бөгөөд хэмжээ ч хангалттай байгаа тул баярлалаа. Мөн сар бүр будааны тусламж үзүүлж өгдөгт баярлалаа” гэсэн юм.

Энэ жил ч 2200ширхэг байцааг Ким Мал жин халамжлагч (69нас) ач хүүг нь эдгээж өгсөн Бурханы ивээлд талархан явуулсан юм. Ким халамжлагчын ач хүү (И Жэ ү, 15нас) төрөөд 8н сартайдаа буцалж буй тостой хайруулын тавганд дүрэгдэн маш ноцтой түлэгдсэн ч И Жей руг тэргүүн пасторын залбирлаар асар хурдан сорвигүй төгс эдгэрсэн юм.

“Гал түймэр дунд Бурханы төгс хамгаалалтыг мэдэрсэн юм”

Пак Ги сон сүмд үйлчлэгч (64нас, 2-р их бүлэг 13-р хэсэг)

Албан байгууллагын оффис интерьер хийдэг би өнгөрсөн 5-р сард ажилчидтайгаа хамт ажил хийж байгаад материал авахаар гарах үед ‘Ажил дээр гал гарлаа’ гэсэн мэдээ ирсэн юм.

Маш хурдан ажил дээрээ иртэл 2ч галын командын машин болон цагдаагийн машин ирсэн байлаа. Ойр орчимд битүү өтгөн утаа болж ажилтнуудыг аюулгүй гаргаж манай хүмүүс галыг газар авахуулахгүй нь тулд ажиллаж байлаа.

Би уг азрын хойд талд гараад гар утсаараа И Жей руг пасторын автомат хариулагчтай холбогдон залбирал авсан юм. Түүний дараа галын голомт руу хүмүүс рүүгээ очиход талархалтай нь галын тархалт зогсон багассаж утаа их гарч байгаа нь багасаж, галын ажилтнууд үйл явцбг хяналтандаа авсан байлаа.

Түүний дараахан дахин тэргүүн пасторын залбирал авах үед гал намжиж гал командынхан утаа сархиулах ажил хийж байсан юм.

Үүгээр дамжуулан би Бурхан хичнээн эрхэм шударга Эрхэм болохыг тэргүүн пасторын залбирлаар баталж өгч байгааг мэдрэх боломжтой болсон юм.

Гал гарсан шалтгаан нь сантехникийн хоолойг тайрах явцад оч үсэрсэнээс болсон бөгөөд тухайн үед хананд нь маш амархан шатаж болзошгүй дуу намсгагч хөөсөнцрөөр доторлосон, гал гарсан газрын цонхны хажууд газтай сав хэдэн ширхэг байсан юм. Мөн таазыг мөн амархан шатах материал, дотор цахилгааны монтажны утаснууд гал газар авсан асар том хэмжээний гал гарч болзошгүй байлаа. Үнэндээ саяхан бидэнтэй ижил ажил авсан өөр нэгэн бригадынхан мөн л ижил шалтгаанаар гал гарч маш их хэмжээний хохирол амссан тухай мэдэх боловч, ийм нөхцөлд ч биднийг төгс хамгаалалт авсан юм. Халлелүяа!

Дараа нь гал гарсан газрын нарийвчлан шалгаж үзэхэд гал гарсан газрууд битүү хар тортог болсон байсан бол, бидний гүйцэтгэж байсан кондишний хоолойд ямарч асуудалгүй байсан бөгөөд хамгийн нарийн хийцтэй таазны ажилд ямар ч гал болон тортог болоогүйг хараад Бурхан төгс хамгаалж өгсөн болохыг баталгаатай олж мэдсэн юм.

Гал командынхан болон тэнд байсан бүх хүмүүс “Том гал гарахаас аргагүй нөхцөл байсан ийм хэмжээний болоод өнгөрнө гэдэг ёстой тэнгэр харж дээ” гэцгээж байлаа. Үүний дараа энэ байдлыг мэдсэн захирал маань харин “Сайн хичээлээ” гэж, мөн өөр ажлуудыг ч даалгаж өгсөн юм.

30н жилийн өмнө Манминий итгэгч болж, амийн сургаалиар дамжуулан Бурханы амьд оршин буйг баттай мэдсэн би гарын шууны ясны хугаралтыг тэргүүн пасторын залбирлаар эдгэрч байсан ба одоо сүмдээ хэсгийн ахлагчаар, эхнэр маань бүлгийн ахлагчаар үйлчилж байна. Авралыг өгч, эдийн засгийн хямралаас огт хамааралгүй байнга ажлаар хангаж, ерөөж өгдөг Бурхандаа бүх талархал алдрыг өргөе.